

МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛЬ
ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ БИЧИГ

№ 14/393

НШУС

2013

МОНГОЛЫН СЭТГҮҮЛ ЗҮЙН СУРГАЛТЫН
ӨНӨӨГИЙН БАЙДАЛ, ХАНДЛАГА

Д. Дагиймаа*

* ХИС, Сэтгүүл зүй, медиа технологийн тэнхимийн эрхлэгч, доктор, профессор

Түлхүүр үг: сэтгүүл зүйн сургалт, магистр, докторын шаталсан сургалт, сэтгүүл зүйн чиглэлээр сургалт явуулж буй их, дээд сургуулиуд, оюутны сургуулиа сонгох шалгуур үзүүлэлт

Mонголын сэтгүүл зүйн сургалтын өнгөрсөн зуун жилийн ололтыг дүгнэж үзэхэд, Монголд сэтгүүл зүйн сургалт хөлөө олж магистр, докторын шаталсан сургалт тогтвортой болсон, ХМХ-үүдээ дотооддоо боловсон хүчинээр хангаж боломжтой болсон, сэтгүүл зүйн сургуулиуд сургалтын стандарттай болсон, сургалтын хөтөлбөр нэг түвшинд ойртох, материаллаг бааз, орчин сайжирсан, сэтгүүл зүйн хөтөлбөрийг магадлан итгэмжлэх эхлэл тавигдаж, сэтгүүлч мэргэжлээр боловсон хүчин бэлтгэдэг гурван сургууль магадлан итгэмжлэгдсэн, дэлхийн жишгээр төгсөгчид мэргэжлээрээ ажиллаж байна гэсэн таатай мэдээлүүд байна.

Ийм ерөнхий дүр зураг гарч буй ч өнөөдөр Монголын сэтгүүл зүйн

сургалтын байдал, хандлага ямар байгааг судлан үзэх нь зайлшгүй хэмээн үзлээ. Өдгөө Монголын ХМХ-үүдийн тоо 500 хол давж, энэ зах зээл дээр чадварлаг боловсон хүчиний эрэлтийн байсаар байна. Монголын ХМХ-ийн тоо буурахгүй нэмэгдэх тухай, түүнийг дагаад боловсон хүчиний эрэлтийн тухай хоёр жилийн өмнө бичиж байсан нь бодитой болжээ¹.

1960 оноос дотооддоо боловсон хүчинээ бэлтгэж эхэлсэн Монголын сэтгүүл зүйн сургалт 1990 оноос хойш хүрээгээ тэлж 2006 онд оргил үедээ хүрч 22 их, дээд сургууль сэтгүүлч бэлтгэж байв.

2013 оны намрын байдлаар сэтгүүлч мэргэжлээр боловсон хүчин бэлтгэдэг 17 сургууль байна. Эдгээр сургуулиудад сэтгүүлч, олон улсын сэтгүүлч, сэтгүүлч-орчуулагч, сэтгүүлч-утга зохиолын ажилтан, телевизийн сэтгүүлч-найруулагч, телевизийн сэтгүүлч-зураглаач, спортын сэтгүүлч мэргэжлээр 1900 орчим оюутан суралцаж байна.

Хүснэгт №1. Монголд сэтгүүл зүйн чиглэлээр сургалт явуулж буй их, дээд сургуулиуд (2013 оны 9 дүгээр сарын байдлаар)

№	Сургуулийн нэр	Сэтгүүл зүйн сургалт эхэлсэн он	Одоо суралцаж буй оюутны тоо
1	МУИС НШУС	1960	260
	МУИС Улаанбаатар сургууль	2006	90
2	ХИС	2004	122
3	МУБИС	1991	150
4	Радио, телевизийн сургууль	1995	350
5	"Отгонтэнгэр" ИС	1998	98
6	"Идэр" ДС	2000	64
7	"Зохиомж" ДС	1999	184
8	"Их Монгол" ДС	1996	40
9	"Улаанбаатар-Эрдэм" их сургууль	1997	32
10	"Их Засаг" ИС	2002	160
11	"Номун далай" ДС	2000	30
12	"Сэтгүүлч" коллеж	2004	100
13	"Орхон" ИС	2009	20
14	Олон улс судлалын ДС	1996	14
15	"Соёл-эрдэм" ДС	2003	45
16	Утга зохиол, нийгмийн ажилтны ДС	1997	48
17	Кино урлагийн ДС	1999	100
	Бүгд		1891


Энэ судалгааг Америкийн сэтгүүл зүйн сургалтын өнөөгийн байдал, хөтөлбөртэй харьцуулан хийв. Учир нь өндөр хөгжсөн энэ орны сэтгүүл зүй манайд загвар болох билээ.

Америкийн Сэтгүүл зүй, олон нийтийн харилцааны боловсролын нийгэмлэг (AEJMC) "Сэтгүүл зүй, олон нийтийн харилцааны элсэлтийн жил бүрийн судалгаа"-г 1988 оноос хийж ирсэн байна. AEJMC-ээс хэвлэж гаргадаг "Journalism & Mass communication Directory" жагсаалтад багтсан сургуулиуд болон Dow Jones News Fund, Inc-ын онлайн бүртгэлд байгаа "The Journalist's Road to Success: A Career Guide"-д бүртгэлтэй сургуулиуд тус судалгаанд хамрагджээ. Эдгээр багтсан коллеж, их сургуулиуд

хамгийн багадаа 10-аас багагүй сэтгүүл зүйн хөтөлбөрийг санал болгодог (энэ хөтөлбөрт нь хэвлэл мэдээлэл, хэвлэлийн хууль, ёс зүй, ур чадвар, редакторлах арга зүй, мэдээлэх зэрэг хөтөлбөрүүд багтсан) коллежаос их сургууль хүртэлх бүх шатны 494 сургууль хамрагджээ. Судалгааг 2011 оны 10 дугаар сараас эхэлж, 4 дэх удаагийн буюу сүүлийн лавлагааг 2012 оны 4 дүгээр сард авсны үндсэн дээр нийтдээ 491 хөтөлбөр судалгаанд хамрагджээ. Эдгээр нь 2010 оныхоос 10 программаар илүү байгаа юм. 491 хөтөлбөрөөс 487 нь бакалавр, 222 нь магистр, 50 нь докторын хөтөлбөрийг санал болгодог байна.

График №1. Олон нийтийн харилцаа ба сэтгүүл зүйн чиглэлээр элсэгчдийн дунд хийсэн жил тутмын судалгаа²

2011 оны Америкийн их, дээд сургуульд Олон нийтийн харилцаа ба сэтгүүл зүйн чиглэлээр элсэгчдийн тоо




2011 оны намар сэтгүүл зүй болон олон нийтийн харилцааны чиглэлээр элсэн суралцагчид өнгөрсөн жилтэй харьцуулахад 2.326 оюутнаар буюу 1.1 хувиар буурчээ. Ерөнхий төлөвийг үзвэл өнгөрсөн жилүүдэд элсэлт нэмэгдэж байсан бөгөөд элсэлт ийн буурч байсан тохиолдол урьд өмнө байсан гүй. Өмнөх жилүүдэд 1990, 1992, 1993, 2009 онд элсэлт буурч байсан нь ажлын байрны эрэлтээс хамаараад зарим их, дээд сургууль элсэлтийн тоондоо хязгаарлалт хийж байсанас үүдэлтэй ажээ. Төгсөх оюутны түвшин 0.5 хувь, төгсөлтийн дараах сургалтын түвшин 7.9 хувиар буурчээ. Гэхдээ

магистрийн зэргийн элсэлт буурснаас биш докторантурын элсэлт 2010 оноос 2011 онд өссөн үзүүлэлт байна.

Монголын их, дээд сургуулийг сэтгүүлч мэргэжлээр төгссөн мэргэжилтний тоог нарийвчлан гаргах оролдлого хийсэн боловч амжилттай болсонгүй. Учир нь сургуулиуд төгсөгчдийн судалгааг нарийвчлан хийдэггүй ба төгсөгчдийн 70 орчим хувь нь мэргэжлийн ажлаа хийдэг гэсэн хариултыг өгчээ. Харин Америкийн сургуулийн төгсөгч, ажил эрхлэлтийн (бүтэн цагаар) түвшинг авч үзвэл дараах байдалтай байна. Нийт төгсөгчдийн 50-70 хүртэлх хувь нь мэргэжлээрээ ажилладаг.

График №2. Сэтгүүл зүй, олон нийтийн харилцааны чиглэлээр элсэгчид, ажил эрхлэлтийн жил бүрийн судалгааны тайлан

Төгсөлт, ажил эрхлэлтийн үзүүлэлт



Монголын сэтгүүл зүйн сургалтын өнөөгийн байдал, тулгамдсан асуудлыг тодорхойлох зорилгоор дээрх сургуулиудын сэтгүүл зүйн тэнхимийн багш, удирдлагуудын дунд 2013 оны 2-р сард ХИС-ийн Сэтгүүл зүй, медиа технологийн тэнхмээс “Монголын сэтгүүл зүйн сургалтын өнөөгийн байдал”, сэтгүүлч мэргэжлээр суралцдаг нийт оюутны дунд “Сэтгүүл зүйн ангийн оюутнуудын сэтгэл ханамжийн судалгаа” сэдэвт судалгаа явуулсан юм. Энэхүү судалгааг тус тэнхмээс 2011 оны 4-р сард

явуулж байсан бөгөөд энэхүү хоёр судалгааг харьцуулан үзүүлэв.

Сургуулиуд бусад сургуулиас ялгарах давуу талаа практик давамгайлсан гэсэн байдлаар тодорхойлж байна. Энэ нь 2011 онд хийсэн судалгаатай ижил үр дүнтэй байна.

Сэтгүүл зүйн сургалт муу хэмээн нийгэм, ХМХ-ийн эздийн зүгээс ирдэг шүүмжлэлийн шалтгааныг сэтгүүл зүйн багш нар дараах байдлаар тайлбарлаж байна.

График №3. Монголын сэтгүүл зүйн сургалтын өнөөгийн байдал

Сэтгүүл зүйн сургалт муу байгаа шалтгааныг сэтгүүл зүйн багш нар дараах байдлаар тайлбарлаж байна



Эндээс үзвэл 2011 онд сургуулиуд төгсөгчдийн чанараа элсэгчдийн чанартай холбож байсан бол 2013 оны судалгаанд багш нар элсэгчдийн чанараас гадна сургалтын чанар муу, материаллаг бааз хангалтгүй байгаатай холбон тайлбарлажээ.


Дээрх графикаас харахад сэтгүүл зүйн сургуулиудын өмнө материаллаг

бааз хангалтгүй байгаа аж. Мэргэжлийн онцлогоос хамаараад нэн шаардлагатай байдаг радио, төле студитэй эсэхийг тодруулахад 2011 онд 7 сургууль студигүй байсан бол энэ жил 2-оор буурч 5 сургууль студигүй гэсэн зерэг үзүүлэлттэй байна. Сэтгүүл зүйн сургалтын өнөөгийн түвшинг багш нар дунд (60%) гэж дүгнэжээ.

Оюутнуудын дунд явуулсан “Сэтгүүл зүйн ангийн оюутнуудын сэтгэл ханамжийн судалгаа”-нд сэтгүүлч бэлтгэдэг дээрх 18 их, дээд сургууль, коллежийн сэтгүүлчийн ангийн 246 оюутан хамрагдсан бөгөөд анкетийн асуулгаар, санамсаргүй түүврийн аргаар мэдээллийг авав. 2011 оны судалгаанд 272 оюутан хамрагдсан юм. Хүйсийн хувьд 77 хувь нь эмэгтэй, 23 хувь

эрэгтэй оюутан байсан бөгөөд курсээр авч үзвэл 54 нь нэг, 56 нь хоёр, 68 нь гурав, 68 нь дөрөвдүгээр курсын оюутан байв. Сэтгүүлчийн ангид суралцаж байгаа оюутнуудын дийлэнх нь буюу 83% хүсэл сонирхлоороо энэ ангид элсээн байдаг байна. Сургуульдаа элсэх дээс сургуулийн нэр хүнд, сургалтын чанар, орчин нөхцөл, хос мэргэжлээр төгсөх боломжийг илүүтэй хардаг ажээ.

График №4. Оюутны сургуулиа сонгох шалгуур үзүүлэлтүүд



“Сэтгүүл зүйн ангид суралцаж байгаадаа сэтгэл хангалуун байдаг уу” гэсэн асуултад 65 хувь нь тийм гэж хариулсан нь өнгөрсөн жилийнхтэй ойролцоо (56%) байна. Дээрх хариултаас үгүй, дунд зэрэг, мэдэхгүй хэмээн

хариулсан 86 оюутан сэтгэл дундуур байгаагийнхаа шалтгааныг материаллаг бааз муу, сургалтын орчин тааруу, хичээлийн хөтөлбөр учир дутагдалтай гэсэн хариултыг өгсөн нь мөн л 2011 оныхтой адил байна.

График №5. Сэтгүүл зүйн ангийн оюутнуудын сэтгэл ханамжийн судалгаа




Харин сургуульдаа сэтгэл дундуур байдаг бол юуг нэрлэх вэ гэсэн асуултад (2011) сэтгүүлчийн ангийн оюутнууд (давхардсан тоогоор) номын сан, түүний үйлчилгээ (55,2%), мэргэжлийн студи, лабораторигүй байдал (51,2%), сургуулийн гаднах талбай, тохижилтын (49,6%) асуудалд хамгийн их сэтгэл дундуур байдгаа илэрхийлсэн бол спорт заал (28.8%), Интернет үйлчилгээ (34.4%), сургалтын албаны ажилчдын

харьцаа (30.4%) бас түүнээс ч дутуугүй бухимдуулдаг гэжээ. Манай оюутнуудын дийлэнх нь телевизийн салбарт ажиллах аж. Харин Америкийн оюутнуудын хамгийн их буюу 29,6% нь ХАА, шинжлэх ухааны гэхчилэн нарийн мэргэшсэн салбарт ажиллах хүсэлтэй-гээ хэлжээ. Үүний дараа 19 хувь нь сэтгүүлчээр ажиллах хүсэлтэй гэж хэлсэн бол PR болон зар сурталчилгааны салбарт 17,6 хувь ажиллана гэжээ.

График №6. Сэтгүүл зүйн ангийн оюутнуудын ажиллах хүсэлтэй салбар

Оюутнууд ХМ-ийн дараах салбаруудад ажиллах хүсэлтэй
(хувиар)

■ 2013 ■ 2011



Сэтгүүл зүйн оюутнууд маань хөтөлбөртөө дараах хичээлийг үзэх сонирхолтой байгаагаа илэрхийлсэн нь

өөрийн ажиллах хэвлэл мэдээллийн салбартай нь холбогдож байна.

График №7. Сургалтын хөтөлбөрийн талаарх оюутнуудын байр суурь




Дээрх үзүүлэлтээс үзэхэд оюутнууд нийгмийн хөгжил, өөрийн хүсч буй ажлын байр, хэвлэл мэдээллийн зах зээлээ дагаад дагаад компьютер график дизайн, хөтлөгчийн ур чадвар, мөн онлайн сэтгүүл зүй, сэтгүүлчийн ур чадвар, дадлага давамгайлсан хичээ-

лийг сургалтын хөтөлбөртөө оруулах хүсчээ.

Ийнхүү манай оюутнуудын анхаарлыг телевизийн салбар татаж байгаа бол америкийн оюутнууд онлайн сэтгүүл зүйг илүүтэй сонирхож байгаа ажээ.

График №8. Олон нийтийн харилцаа ба сэтгүүл зүйн чиглэлээр элсэгчдийн дунд хийсэн жил тутмын судалгаа

Америкийн сургуулиудын сэтгүүл зүйн сургалтын хөтөлбөрт орсон өөрчлөлт




Сэтгүүл зүйн чиглэлээр хамгийн чанартай сургалт явуулдаг гурван сургуулийг нэрлэнэ үү гэсэн нээлттэй

асуултанд дараах байдлаар хариулсан байна.

График №7. Сэтгүүл зүйн ангийн оюутнуудын сэтгэл ханамжийн судалгаа

Монголын сэтгүүл зүйн топ 6 сургууль



Дүгнэж үзвэл, сэтгүүл зүйн сургуулиудын багшлах боловсон хүчин, сургалтын орчин, материаллаг бааз жилээс жилд сайжирч байгаа дүр зураг гарч байна. Ойрын жилүүдэд элсэгч, төгсөгчдийн тоо харьцангуй тогтмол байна. Гэхдээ 1990 оноос хойш сэтгүүлчээр төгссөн боловсон хучнийг судлах, тэдний зах зээлийн шаардлагад нийцэж байгаа эсэхийг байнга судалж байх зайлшгүй шаардлагатай юм.

Монголын сэтгүүл зүйн сургуулиудын өмнө сургалтын материаллаг баазаа сайжруулах, сэтгүүл зүйн багш нарын мэдлэгийг дээшлүүлэх, практик давамгайлсан сургалтыг хэрэгжүүлэх, элсэгчдийн суурь мэдлэгийг дээшлүүлэх зэрэг асуудал тулгарч байна. Дээрх тулгамдсан асуудлууд бодитой оршин байгааг сэтгүүл зүйн

сургалт эрхэлж буй байгууллагууд хүлээн зөвшөөрч байна.

Ишлэл

¹ 2011. Ардчилал, шинэчлэлийн үеийн Монголын сэтгүүл зүйн боловсролын асуудал // «Сэтгүүл зүй» МУИС-ийн эрдэм шинжилгээний бичиг. №12 (370), 158 дахь тал.

² 2012. Journalism & Mass communication educator. AEJMC. Volume 67, p. 338.

Ашигласан материалын жагсаалт

1. Зулькафиль М., Норовсүрэн Л. 2010. Сэтгүүл зүйн тэнхим - 50 жил (Түүхийн товчоо). УБ.
2. Норовсүрэн Л. 2001. Монголын сэтгүүл зүйн түүхэн тойм. УБ.
3. 2011. «Сэтгүүл зүй» МУИС-ийн эрдэм шинжилгээний бичиг. №12 (370).
4. 2012. Journalism & Mass communication educator. AEJMC. Volume 67.

Summary

National University of Mongolia offered the first journalism courses in Mongolia, in 1960. Nowadays 17 universities' journalism courses are preparing journalists, editors, reporters for all of Mongolians mass media. There are about 1900 students are studying. Between 1960 and 1995 journalism education only offered a bachelors's degree in journalism. By 2013, 17 universities were offering at least a bachelor's degree in journalism, about half a dozen offered Master's degree and 3 universities had

doctoral programs. We designed questionnaire. I gave questionnaire a chairman of journalism education department in 18 universities. And we asked the chairman to give the questionnaire to the one of the professors or to answer the questionnaire himself. We designed another questionnaire which I gave students of journalism 246 students participated. Journalism universities must solve these problems: Improve practical materials (practical training), Improve quality of teaching, Professors should be better, Students must have higher level basic general knowledge.

Тураач улсын төслийн хувь нийтийн хувьнад хөтөлж, Датаком компани 1996 онд Интернетийн сүлжээ буюу Июнайт Монголын Интернет-бийтгэлийн сурье тэврийдсан бийна. Сүрье хэлбэрэд 1996 оны 1-р сарын 27-нд Монгол Улсад Интернет холбогдуулалтад "Тэдээ зарлажээ"

Тураач улсын төслийн хувь нийтийн хувьнад хөтөлж, Датаком компани 1996 онд Интернетийн сүлжээ буюу Июнайт Монголын Интернет-бийтгэлийн сурье тэврийдсан бийна. Сүрье хэлбэрэд 1996 оны 1-р сарын 27-нд Монгол Улсад Интернет холбогдуулалтад "Тэдээ зарлажээ"